



МОНГОЛ УЛСЫН  
БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ,  
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙДЫН  
ТУШААЛ

2015 оны 11 сарын 03 өдөр

Дугаар А/378

Улаанбаатар хот

Тушаалын хавсралтад нэмэлт,  
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Монгол Улсын Их Хурлын 2010 оны 24 дүгээр тогтоолоор баталсан "Ус" үндэсний хөтөлбөрийн 3.3.21 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 120 дугаар тогтоолоор баталсан "Монгол улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний 238.2 дахь зорилтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм батлах тухай" Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А-301 дүгээр тушаалын 3 дугаар хавсралтын 6 дахь дугаарын сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэр "- ааруул", "- тараг" гэсний өмнө "тонн" гэж, "- зайрмаг" гэсний өмнө "- 1000 ш" гэж, 6 дугаар хавсралтын 12 дахь дугаарын төмөр бетон эдлэлийн үйлдвэр "- буто бетон" гэсний өмнө "м<sup>3</sup>" гэж тус тус нэмсүгэй.

2. Мөн тушаалын 2 дугаар хавсралтын 1.1 дэх дугаарын алтны шороон орд угаан баяжуулах хэмжих нэгж "тонн" гэснийг "м<sup>3</sup>" гэж, 1.17 дахь дугаарын элс, хайрга "- гидромеханик аргаар олборлох", "- угаах" хэмжих нэгж "тонн" гэснийг "м<sup>3</sup>" гэж, 6 дугаар хавсралтын 12 дахь дугаарын төмөр бетон эдлэлийн үйлдвэр "- төмөр бетон" хэмжих нэгж "м" гэснийг "м<sup>3</sup>" гэж тус тус өөрчилсүгэй.

3. Энэхүү тушаалыг мөрдүүлэх, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус яамны Газар зохион байгуулалт болон усны нэгдсэн бодлого зохицуулалтын газар /Г.Мөнх-Эрдэм/-т даалгасугай.

САЙД  Н БАТЦЭРЭГ



011173